



ХӨЛ ХОРИОНЫ ҮЕД ИРГЭНИЙГ ГЭРТ НЬ ЛАЦДАХ, ТҮГЖИХ АРГА ХЭМЖЭЭ АВАХ НЬ ХУУЛЬ БУС БОЛОХ ТУХАЙ

НЭГ. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Коронавируст цар тахлын халдварын тохиолдол голомтлон тархсаныг хязгаарлах зорилгоор шат шатны онцгой комисс өөр өөрсдийн зүгээс анхаарал хандуулан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд Дархан-Уул аймгийн Дархан сумын Онцгой комисс 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр 01 дугаартай мэдэгдэл гаргаж түүнд туссан шаардлагыг¹ зөрчсөн тохиолдолд хүний эрхийг ноцтой зөрчихүйц шийтгэл оногдуулахаар

тусгажээ. Үүнд “Дээрх 4 шаардлагыг мөрдөөгүй зөрчсөн тохиолдолд Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дугаар зүйлийн 271.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу аймгийн Цагдаагийн газарт шилжүүлж, шаардлагатай тохиолдолд тухайн өрхийн хаалгыг лацдах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг анхааруулж байна” гэжээ.

ХОЁР. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Цар тахлын үед хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах шийдвэр гаргахдаа Гамшгаас хамгаалах тухай хууль болон Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасан шаардлагыг хангах ёстой.

1. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гарсан байх²

Цар тахлын үед хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг Гамшгаас хамгаалах тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд дор дурдсаны дагуу зохицуулжээ. Үүнд:

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дугаар зүйлийн 271.3-т “Онцгой комиссын шийдвэр, тогтоосон хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг сахин мөрдөхийг тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, иргэнээс шаардана”, мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т “Иргэн гамшгаас хамгаалах талаар үүрэг хүлээх тухай” тусгасан. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон

¹ Дархан-Уул аймгийн Дархан сумын онцгой комиссоос 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Дугаар 01 мэдэгдэлд туссан шаардлага 1. нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, 2. шинжилгээнд хамрагдах, 3. ирээд байрлах хаяг, 4. өөрийн гэрээс 14 хоногийн хугацаанд гарахгүй өөрийгөө тусгаарлах

² Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.1 дэх заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт

хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж зохицуулжээ.

Дээрх хариуцлагын арга хэмжээ нь шаардлага хүргүүлэх, торгох, баривчлах тухай тусгаснаас бус гэрийн үүдийг лацдаж, цоожлох тухай огт дурдаагүй. Тиймээс “гэрийн үүдийг лацдаж, цоожлох” арга хэмжээ нь хүний эрх, эрх чөлөөг ноцтой хязгаарлаж буй хэлбэр бөгөөд хуульд заасан үндэслэл, журмын дагуу байх зарчимд нийцэхгүй байна.

2. Хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх³

Хэдийгээр иргэн тусгаарлагдах дэглэмийг сахих үүрэгтэй боловч сахиагүй тохиолдолд иргэнийг гэрт нь албадлагын журмаар лацдаж, цоожлох нь баривчлах арга хэмжээтэй нэгэн адил болно. Иргэний гэр шорон биш бөгөөд гэртээ тусгаарлагдаж буй иргэн нь “сэжигтэн, яллагдагч” биш тул энэхүү аргыг хэрэглэх нь хүнлэг бус байна. Бодит байдал дээр хөл хорио тогтоох нь тодорхой хэмжээний хорьж буй хэлбэр⁴ тул иргэд сэтгэл зүйн дарамтад ордог. Иймд аливаа арга хэмжээ нь хүнлэг, хүний эрхийг эдлүүлэх боломж нөхцөлөөр хангасан байх ёстой. Хөл хорионд буй иргэний гэрийг лацдах, цоожлох арга хэмжээ нь хүнлэг бус байх тул хүний эрхийг хязгаарлах хязгаарлалтын зарчимд нийцэхгүй байна.

3. Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журам, нийтийн ёс суртахуун, нийгмийн эрүүл мэнд, эсхүл хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон байх, хамгийн бага хязгаарласан байх⁵

Улаанбаатар хотоос орон нутагт ирж буй иргэд 14 хоног тусгаарлагдаж байгаа нь иргэн өөрөө өөрийгөө тусгаарлах арга хэмжээ юм. Энэхүү тусгаарлах арга хэмжээг Шадар сайдын 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан журмаар зохицуулсан. Цагдаа, мэргэжлийн хяналт, багийн Засаг дарга, холбогдох бусад хүмүүс тус журмын хүрээнд хяналт тавьж байна. Түүнчлэн гэрийн хөл хорионд буй иргэдийн гар утсанд QR код бүхий хяналтын систем суулгах замаар хяналт тавих боломжтой болсон. Дээрх дэглэмийг сахихгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар торгох, баривчлах арга хэмжээг авч болохоор зохицуулсан. Тиймээс иргэнийг гэртээ хүн урьж байгаа эсэх, гэрээсээ гарсан эсэхийг хянах олон арга хэрэгслийг хэрэглэх боломжтой байхад ардчилсан нийгмийн үнэт зүйлд хор хөнөөлтэй иргэний гэрийг лацдаж, цоожлох арга хэмжээ авах нь зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон бөгөөд хамгийн бага хязгаарласан байх шаардлагад нийцэхгүй байна.

Цар тахлын үед хүний эрхийг хязгаарлах шийдвэр, арга хэмжээ авахдаа дээрх зарчим, шаардлагыг хангасан байхыг шаарддаг. Түүнчлэн Коронавирусын цар тахалтай холбоотойгоор НҮБ-ын Эрүүдэн шүүхийн эсрэг дэд хорооноос оролцогч улс орнуудад энэ оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн зөвлөмжид “Ямар нэг байдлаар хөл хорионд орсон хүнийг хоригдол мэт харж, харьцаж үл болно⁶” хэмээн дурджээ.

³ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.4 дэх заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт

⁴ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон оролцогч улс орнуудад 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн зөвлөмж. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 95-96 дахь тал

⁵ Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.2, 10.10 дахь заалт, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 11.3 дахь заалт

⁶ Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхээс урьдчилан сэргийлэх дэд хорооноос урьдчилан сэргийлэх үндэсний механизм болон оролцогч улс орнуудад 2020 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн зөвлөмж. Хүний эрх сэтгүүл: Онол, арга зүйн сэтгүүл. Улаанбаатар хот., 2020/№1, 95-96 дахь тал

Хөл хорионд буй иргэний гэрийг лацдах, цоожлох арга хэмжээ авах нь иргэнийг хоригдол мэт харж, харьцаж буй үйлдэл юм. Улсын онцгой комисс болон аймаг, сумын онцгой комисс шийдвэр гаргахдаа НҮБ-ын хүний эрхийн механизм, Хүний

эрхийн үндэсний комисс, судлаачдын гаргасан санал, зөвлөмж, удирдамжийг анхааран үзэх нь Үндсэн хуульд заасан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийн зарчимд нийцнэ хэмээн дүгнэж байна.

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Хөл хорионд тусгаарлагдаж буй иргэний гэрийн үүдийг лацдах, цоожлох арга хэмжээ авах мэдэгдлийг нэн даруй хүчингүй болгох;
2. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд оногдуулах хариуцлагын арга хэмжээнээс хэтрүүлэн, нэг зөрчилд олон хариуцлага оногдуулахгүй байх;
3. Хөл хорионд тусгаарлагдаж буй иргэнтэй хүнлэг бус харьцахгүй байх;
4. Хөл хорионд тусгаарлагдаж буй иргэний зорчих эрхийг хязгаарлах, хяналтад авахдаа нэг арга хэмжээг хэрэглэхээс бус, олон арга хэмжээг зэрэгцүүлэн хэрэглэхээс зайлсхийх;
5. Хөл хорионд тусгаарлагдаж буй иргэнийг хоригдол, халдвар тээгч мэт харж, ялгаварлан гадуурхахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх;
6. Иргэний зорчих эрхийг хязгаарлахдаа хамгийн бага хязгаарлах арга хэмжээг сонгон хэрэглэх.

